


ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТАНИЛЦУУЛГА

Компанийн танилцуулга

“Нако түлш” компани нь Монгол улсад анхны хагас коксын үйлдвэрийг барьж ашиглалтанд оруулах зорилгоор 2007 онд байгуулагдсан. Хагас коксын бүтээгдэхүүн үйлдвэрлэх төсөл нь анх 2007 оноос хэрэгжиж эхэлсэн ба төсөлд шаардлагатай 900 сая төгрөгийн санхүүжилтийг firm commitment хэлбэрээр татан төвлөрүүлж 2008 оны 7 сард 11 сая ширхэг хувьцааг МХБ-д бүртгүүлэн хувьцаагаа олон нийтэд санал болгон арилжаалсан. “Нако түлш” ХК нь жилд 40000 тн хагас кокс, 20000 тн брикет, 5000 тн коксын тос үйлдвэрлэх хүчин чадалтай.

Компаний бүтэц, зохион байгуулалт



“Нако түлш” ХК нь 2007 оноос эхлэн хувьцаат компаний хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд тухайн компаний эрх барих дээд байгууллага нь хувь нийлүүлэгчдийн хурал юм. Компанийн хувь нийлүүлэгчдийн хурлаас сонгогдсон Төлөөлөн Удирдах Зөвлөл нь компаний үйл ажиллагааны стратегийн бодлогыг тодорхойлон ажиллаж байгаа бол компанийн гүйцэтгэх захирал нь өдөр тутмын үйл ажиллагааг удирдан ажиллаж байна.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүн:

1. Д.Даянбилгүүн –“БиДиСЕК”ХК-ийн гүйцэтгэх захирал
2. Б.Лхагвадорж –“БиДиСЕК”ХК-ийн тэргүүн дэд захирал
3. С.Пүрэвсүрэн – “БиДиСЕК” ХК-ийн дотоод албаны менежер
4. Ж.Бат - “Нако түлш” ХК-ийн гүйцэтгэх захирал
5. Б.Батцэцэг- “Нако түлш” ХК-ийн дэд захирал
6. James Passin – Firebird management хөрөнгө оруулалтын менежер
7. Milewski Anthony- Firebird management хөрөнгө оруулалтын мэргэжилтэн
8. Davidoff Nicholas - Firebird management хөрөнгө оруулалтын мэргэжилтэн
9. Б.Амарбаясгалан –“БиДиСЕК”ХК-ийн ерөнхий менежер

Хянан шалгагч:

1. Ж.Нямбилэг– “БиДиСЕК” ХК-ийн нягтлан бодогч

Аудитын компани:

- Компани нь 2008 онд “Коласт” ХХК-тай гэрээ байгуулан хараат бус аудитаар ажиллуулав.
- 2009 оны санхүүгийн тайланд “Далай ван” ХХК-тай гэрээ байгуулан аудит хийлгэсэн.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Жигжид овогтой Бат тус компанийн гүйцэтгэх захирлын албыг 2007 оноос хашиж байна. 1959 онд Архангай аймгийн Цэцэрлэг суманд төрсөн. Монгол Улсын Их Сургуулийг уул уурхайн инженер мэргэжлээр 1977 –ноос 1987 онд дүүргэсэн. ШУТИС –ийн Уул Уурхайн Инженерийн Сургууль төгсөж 2006 онд уул уурхайн зөвлөх инженер болсон.

Ажлын туршлага

- 1982-1986 онд Шарын голын уурхайд мастер, инженер
- 1987-1997 онд ШУТИС-ийн уул уурхайн тэнхимд эрдэм шинжилгээний ажилтан
- 1998-2008 онд Монгол-Оросын хамтарсан “УБИР” ХХК, “Голден Хаус” ХХК-д менежер
- 2000-2007 онд “Мөнхийн Оргил” ХХК-ийн захирал